

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Аудит хийх үндэслэл: Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны “Аудитын ажлын төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Өдөр тутмын үйл ажиллагааны хяналт сайн хэрэгжсэн боловч бодлогын төлөвлөлт, хөрөнгө оруулалтын ажлын бүртгэл, архивын баримтын хөтлөлт, томоохон худалдан авалт зэрэгт зохих түвшний хяналт орхигдсон байна.



Аудитын нэр:

“Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төсвийн болон ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн”

**Баруун-Урт сум
2017 он**

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:

ААГ-ын аудитын хэлтэс

Сүхбаатар аймаг
дахь Төрийн
аудитын газрын
дарга, тэргүүлэх
аудитор М.Нарантуяа

Аудитын
менежер Г.Даваа

Ахлах аудитор Г.Оюунболд
Аудитор О.Барчидгүнсэн
Аудитор Э.Алтансүх

2017 оны 09 дүгээр сарын 25-ны
өдөр

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал багийн утас 70512123,
70512127

Газрын дарга, тэргүүлэх аудитор
70518396 дугаарын факсаар
харилцана уу

ХАЯГ:

Сүхбаатар аймаг дахь Төрийн
аудитын газар, Баруун-Урт сум, 7-р
баг, Нутгийн удирдлагын ордон,
өрөө №226 тоот

Сүхбаатар аймаг
Баруун-Урт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
Товчилсон үгийн тайлбар	4
1.1. Хоёр нэр төрлийн орлогоос бусад татварын орлогыг бодитой төлөвлөж бүрэн биелэжээ.	5
1.2. Батлагдсан төсвөө үр дүнтэй зарцуулсан байна.	5
1.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна.	6
2.1. Мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан заалтуудаас хөрөнгө санхүүтэй холбоотой ажил хийгдээгүй байна.	7
2.2. Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх шаардлагатай байна.	8
2.3. ЗДТГ-ын мэргэжилтэнгүүдийн үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлтийг холбогдох журам, аргачлалын дагуу төлөвлөж, дүгнээгүй байна.	8
2.4. Хөрөнгийн шинж чанартай зарим ажлууд хэрэгжээгүйг эс тооцвол төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна.	9
3.1. Хөрөнгө, санхүүжилттэй холбоотой гарсан ИТХ-ын тогтоол, засаг даргын захирамж хэрэгжээгүй байна.	10
3.2. Гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлага бүрэн биелэсэн байна.	11
3.3. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэжээ.	11
3.4. Архивын байнга, түр хадгалах баримтын данс бүртгэлтэй холбоотой алдаа, дутагдлыг эс тооцвол дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж байна.	12
Аудитын дүгнэлт	13
Аудитын зөвлөмж	14
Холбогдох байгууллагын санал	15
Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын тайлбар	16

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны “Аудитын ажлын төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төсвийн болон ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын дараах чиглэлийг нарийвчлан авч үзэж, үнэлэлт дүгнэлт өгөв. Үүнд:

- I. Төсвийн болон ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаа, үр дүн
- II. Орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын ажилчдын үр дүнгийн гэрээний биелэлт
- III. Хууль тогтоомж, эрх зүйн актын биелэлт түүнд тавьж буй дотоод хяналт үр дүн

Аудит хамарсан хүрээ

Аудитад Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төсвийн болон ОНӨААТҮГ-уудын 2016 оны борлуулалтын орлого, санхүүгийн баримт материал, бодлогын бичиг баримт, үйл ажиллагааны холбогдох баримт материалуудыг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СБА	Сүхбаатар аймаг
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Дэд зорилт-1. Төсвийн болон ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаа, үр дүн

1

БҮЛЭГ 1

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаагүй, Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг төлүүлэхэд анхаарч хуулийн байгууллагад шилжүүлэх шаардлагатай байна.

Хоёр нэр төрлийн орлогоос бусад татварын орлогыг бодитой төлөвлөж бүрэн биелэжээ.

1.1.1. Орон нутгийн төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлогыг төлөвлөхдөө өмнөх оны төлөвлөсөн орлогоос 10,971.2 мянга, гарсан гүйцэтгэлээс 10,062.8 мянган төгрөгөөр их буюу 25,680.0 мянган төгрөгөөр төлөвлөжээ.

1.1.2. Тайлант онд орон нутгийн орлого 26,496.5 мянган төгрөг төвлөрч 103.1%-иар биелэсэн. Төлөвлөгөө их хэмжээгээр давсан тасарсан гол нэр бүхий татварын орлогыг авч үзвэл: Бусад нэр заагдаагүй орлогын хувьд 3,870.2 мянган төгрөгөөр тасарсан бөгөөд төсөвт байгууллагууд бараа материалын худалдан авалтыг хувь хүнээс бус аж ахуйн нэгжээс авдаг болсонтой холбоотой. Харин суутгагчийн хувь хүнд олгосон албан татвараас суутгах албан татварын 4,350.3 мянган төгрөгөөр давж биелэсэн нь мал бүхий иргэд сүүлийн жилүүдэд арьс шир, ноос ноолуурын урамшуулалд өргөн хамрагдах болсоноор нэмэгдэх гол шалтгаан болсон байна. Дээрх хоёр төрлийн орлогоос бусад татварын орлогыг бодитой төлөвлөж бүрэн биелүүлсэн бөгөөд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

1.1.3. Тус сумын Соёлын төв нь 2016 онд 1,900.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөсөн бөгөөд 1,962.6 мянган төгрөгийн орлого төвлөрч, 62.6 мянган төгрөгөөр давж биелэсэн байна.

Батлагдсан төсвөө үр дүнтэй зарцуулсан байна.

1.2.1. Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь 364,716.5 мянган төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж 357,395.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан. 2016 оны эцсээр авлага 3,255.8 мянга, өглөг 34537.6 мянган төгрөг, 2017 оны эхний хагас жилийн байдлаар авлага 23789.7 мянга, өглөг 27,667.4 мянган төгрөгөөр өссөн байна. Орон нутгийн төсөвт байгууллагууд халаалтын хөлс дутуу өгсөн нь авлага өсөх, хувь хүнд нүүрс тээврийн хөлс дутуу олгосон нь өглөг өсөх гол шалтгаан болжээ. Цаашид өглөг, авлагыг бууруулж ажиллах тал дээр тодорхой ажил зохион байгуулж төсөвт байгууллагуудаас авах авлагыг бүрэн авч өглөгийг барагдуулах шаардлагатай байна.

1.2.2. Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2016 онд Олгой ХХК, Талын гал ХХК-иудтай байгуулсан “Нүүрс худалдан авах” гэрээний хэрэгжилтэд өртөг, үр ашгийн тооцоолол хийж үзлээ. Талын гал ХХК-иас худалдан авсан нүүрсний өртгийг Олгой булаг ХХК-иинхтай харьцуулахад 11.0 сая төгрөгөөр илүү байна. Гэрээний хэрэгжилтээс 11.0 сая төгрөгийн хэмнэлт хийх боломжийг алджээ.

1.2.3. Хүүхдийн цэцэрлэгийн төсвийн зарцуулалтад аудит хийх явцад хоолны зардлаас 500.0 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авч төсвийг зориулалт бус зарцуулсан зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 заалтыг зөрчсөн бөгөөд уг зөрчлийн шинж чанарт тохируулан төлбөрийн акт тогтоолоо.

1.2.4. Тус сумын Эрүүл мэндийн төвийн үйлчлэгч /асрагч/ нарт 2016 онд 1 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгоогүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5.2¹, 49.1², 50.2³ дахь заалт, Засгийн газрын 1999 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан “Ажлын цагийг нэгтгэн бодох журам”-ын 10⁴ дахь заалтыг тус тус зөрчсөн тул дутуу олгосон илүү цагийн хөлсийг нөхөн олгуулах төлбөрийн акт тогтоолоо.

1.2.5. Мөн цэцэрлэгийн төсвийн шууд захирагч түлш халаалтын зардлын бодит гүйцэтгэл, норм нормативт үндэслэн жилд дунджаар 23.8-25.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, зарцуулдаг байна. Гэтэл ТЕЗ-аас түлш халаалтын төсвийг үндэслэлгүй өсгөж 2016, 2017 онуудад 37.8 сая төгрөг хуваарилан, илүү буюу хэмнэгдэн үлдсэн 14.0 сая төгрөгийн бодит бус хэмнэлтийг тусгай шилжүүлгийн багцад татан төвлөрүүлдэг зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁵ дэх заалтыг зөрчиж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна.

1.3.1. Дарьганга сумын хувьд “Сумын өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 25 дугаар тогтоолоор 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Сумын өмч хамгаалах байнгын

¹ 5.2. Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй.

² 49.1. Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно.

³ 50.2. Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно.

⁴ Тооцоот хугацааны ажлын цагийн фондоос хэтрүүлэн ажилласан цагийг энэ журмын 8-д зааснаар нөхөн амруулахаар зохицуулж чадаагүй, 9-д дурдсанаар биеэр нөхөн амруулаагүй тохиолдолд хэтрүүлэн ажилласан цагт ногдох цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу цагийн тарифт цалинг 1.5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлэн тооцож олгоно.

⁵ 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

зөвлөлөөс 2016 онд хөрөнгөтэй холбоотой асуудлаар ямар нэгэн санал, шийдвэр гараагүй байна.

1.3.2. Орон нутгийн хөгжлийн сангаар 2016 онд 193623.2 мянган төгрөгийг өмнөх онд хийгдсэн ажлын үлдэгдэл болон шинээр хэрэгжүүлсэн ажилд зарцуулсанаас 10000.0 мянган төгрөгийн ногооны талбай, 40618.2 мянган төгрөгийн авто зам, 22500.0 мянган төгрөгийн бэлчээр усжуулах 5 ширхэг худаг, 14500.0 мянган төгрөгийн цэвэр усны шугам нийт 87618.2 мянган төгрөгийн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.2 дах заалтыг зөрчиж данс бүртгэлд тусгаагүй байна. Дээрх хөрөнгийг данс бүртгэлд тусгуулахаар хугацаатай албан шаардлага өглөө.

1.3.3. ЕБС-ийн данс бүртгэл дэх хөрөнгө материалаас багш нарын албан хэрэгцээнд ашиглаж буй 32 зөөврийн компьютер болон сургуулийн номын сангийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй хөрөнгүүдийг түүврийн тооллогод хамруулж, ашиглаж буй албан тушаалтан бүрээр нэг бүрчлэн тулган баталгаажуулахад бүрэн бүтэн, хэвийн ашиглагдаж байна.

Дэд зорилт-2. Орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын ажилчидын үр дүнгийн гэрээний биелэлт

2

БҮЛЭГ 2

Мэргэжилтэнүүдийн үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлтийг холбогдох журам, аргачлалын дагуу төлөвлөж, дүгнээгүй байна.

Мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан заалтуудаас хөрөнгө санхүүтэй холбоотой ажлууд хийгдээгүй байна.

2.1.1. Дарьганга сумын засаг даргын 2012-2016 онд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөөс 12 заалт хэрэгжээгүй бөгөөд заалт бүрийг авч үзвэл: Иргэдийн оролцоотой 16 айлын орон сууц барих, мал нядалгааны газар байгуулах, дотуур байрны барилга, гамшгийн үеийн зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулах зорилгоор бүх нийтийн сирень дохиотой болох, мах махан бүтээгдэхүүний төрөлжсөн захтай болох зэрэг ажлууд нь огт хийгдээгүй. Хөдөөгийн малчидад сонин хэвлэл захиалах ажлыг хэрэгжүүлэхэд багийн засаг дарга нарын идэвхи сул байснаас гадна, иргэд олон нийтийн цахим сүлжээ, өргөн сүлжээний зурагт, радиогоор бүрэн хангагдсан тул хэвлэл захиалаагүй байна.

2.1.2. Үндсэн чиглэлийн хэрэгжилт 2017 оны эхний хагас жилийн байдлаар 29 зорилт удааширалтай байгаа бөгөөд 4 зорилт огт хэрэгжээгүй байна. Үүнд: Дагшин булгийн эхийг хамгаалах, багш хөгжлийн төвийг байгуулж тохижуулах, ганга нуурын чуулган түүх соёл байгаль экологи аялал жуулчлалын өдөрлөг, төрийн архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлууд хийгдээгүй байна.

2.1.3. Мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан хэрэгжээгүй заалтууд нь төсөвт хөрөнгө дутагдалтай, өөрийн нөөц бололцооноос хэтэрсэн арга хэмжээ төлөвлөсөнтэй холбоотой байна. Иймд Мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлийг төлөвлөх үйл ажиллагааг сайжруулж, удирдлагын хэрэгжүүлэх хяналт шинжилгээг чанаржуулан, сум орон нутгийн төсвийн гүйцэтгэл, эдийн засагт тулгуурлан боловсруулах шаардлага үүссэн байна.

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх шаардлагатай байна.

2.2.1. Засгийн газрын 134-р тогтоол гарсантай холбогдуулан тус суманд 2012 оноос 57 иргэнд нийт 344200.0 мянган төгрөгийн зээл олгожээ. 2017 оны 09 сарын 13-ны байдлаар зээлийн эргэн төлөлтийн хугацаа дууссан боловч төлөгдөөгүй байгаа 25 иргэний 70623.0 мянган төгрөг, хугацаа дуусаагүй 9 иргэний 30246.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

2.2.2. Зээлийн эргэн төлөлт дутуу байгаа зээлдэгч нараас 22 иргэний төсөл, арга хэмжээ хэвийн хэрэгжиж байгаа бол 12 иргэний төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, зээлээ хугацаандаа төлөөгүй байна. Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн эргэн төлөлт, төсөл арга хэмжээг сайжруулж ажиллах талаар сумын ИТХ-ын 2016 оны 7-р сарын 29-ны өдрийн 01 тоот тогтоол гарсантай холбогдуулан хяналтын зөвлөлөөс иргэдтэй уулзаж мэдэгдэх хуудас удаа дараа өгсөн боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна. Иймд дээрх хэрэгжээгүй төсөл арга хэмжээ, төлөөгүй байгаа зээлийн үлдэгдлийг төлүүлэх, хуулийн байгууллагад шилжүүлэх шаардлагатай байна. Аудитын хугацаанд Дарьганга сумын Сум хөгжүүлэх сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг санхүүгийн программд шилжүүлж, тус санг хариуцсан нягтлан бодогчид холбогдох ажил гүйлгээг журнал, дэлгэрэнгүй бүртгэлд хэрхэн хөтлөх талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

ЗДТГ-ын мэргэжилтэнүүдийн үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлтийг холбогдох журам, аргачлалын дагуу төлөвлөж, дүгнээгүй байна.

2.3.1. Тус сумын ЗДТГ-ын хувьд Санхүүгийн албаны дарга, Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга, Төрийн сангийн төлөөлөгч, Дотоод ажил хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн, Хүн ам зүй, нийгмийн хамгааллын бодлогын мэргэжилтэн, Газрын даамал, МААҮТҮБХ мэргэжилтэн, Байгаль орчин аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн зэрэг нийт 8 албан хаагч үр дүнгийн гэрээ байгуулж ажилладаг байна.

2.3.2. Дээрх мэргэжилтнүүдийн хувьд тусгай ажил үйлчилгээнээс бусад 167 ажил үйлчилгээ, тусгай ажил үйлчилгээ 68, нийт 235 ажил үйлчилгээг 2016 оны үр дүнгийн гэрээндээ тусгаж ажилласнаас биелэлт гаргасан 206 ажил үйлчилгээ байна. Биелэлт гараагүй 29 ажил үйлчилгээг хэрэгжээгүй шалтгаан, нөхцлөөр нь

ангилж авч үзэхэд төсөв санхүүтэй холбоотой 1, төлөвлөсөн арга хэмжээ зохион байгуулагдаагүйтэй холбоотой /*тухайн мэргэжилтнээс үл хамаарсан*/ 2, агуулгын хувьд ижил ажил үйлчилгээг давхардуулан төлөвлөсөнтэй холбоотой 9, өөрийн ажил үүрэгт хамааралгүй ажил үйлчилгээг үр дүнгийн гэрээндээ тусгасантай холбоотой 13, ямар нэгэн шалтгаангүйгээр тодорхой ажил хийгдээгүй 4 ажил үйлчилгээ байна. Үр дүнгийн гэрээг холбогдох аргачлалын дагуу байгуулсан боловч гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг давхардуулсан, хэрэгжих боломжгүй ажлыг төлөвлөсөн байна.

2.3.3. Сумын мэргэжилтнүүдийн 2016 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг ЗДТГ-ын дарга 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдөр дүгнэсэн бөгөөд 2 албан хаагч “А”, 6 албан хаагч “В” үнэлгээтэй дүгнэгджээ. Төрийн жинхэнэ албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхдээ дараах алдаа, дутагдал гаргасан байна. Тодруулбал: Батлагдсан маягт дахь үг, үсгийг өөрчилсөн, хассан буюу маягтын дагуу гаргаагүй байхад үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэсэн. Түүнчлэн биелэлтийг дүгнэсэн албан тушаалтан холбогдох тэмдэглэгээ, гарын үсгийг бүрэн бус хөтөлсөн нь “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын хавсралт “Үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх аргачлал”-тай нийцэхгүй байна. Иймд холбогдох зөвлөмжийг хүргүүллээ.

2.3.4. Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилчдын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарыг нягтлан үзэхэд зарим ажилтан, албан хаагч нарын ажлын байрны тодорхойлолт гарын үсэг, тамга тэмдэггүй, гүйцэтгэх ажил, чиг үүргийг тодорхой бус тусгасан, Соёлын төвийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлаагүй байна. Эдгээр нь Хөдөлмөрийн тухай хуулийн 48.3.2⁶ дахь заалт, БСШУС-ын 2007 оны 351 дүгээр тушаалаар батлагдсан “Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт”-той нийцэхгүй байна.

Хөрөнгийн шинж чанартай зарим ажлууд хэрэгжээгүйг эс тооцвол төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна.

2.4.1. Тус сумын төсөвт байгууллагуудын 2016 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөсөн ажил үйлчилгээ, түүний биелэлтэд дүн шинжилгээ хийв. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургууль: Нийт 34 ажил үйлчилгээ төлөвлөсний 12 нь тусгай ажил үйлчилгээ байна. Үүнээс 3 тусгай ажил үйлчилгээ хэрэгжээгүй.
- Хүүхдийн цэцэрлэг: Нийт 56 ажил үйлчилгээ төлөвлөсөний 21 нь тусгай ажил үйлчилгээ байна. Үүнээс 1 тусгай ажил үйлчилгээ хэрэгжээгүй.

⁶ 48.3.Ажил олгогч нь хууль тогтоомж, хамтын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн дараахь журмыг баталж мөрдүүлнэ: 48.3.2.ажлын байрны тодорхойлолт болон албан тушаалын лавлах;

- Эрүүл мэндийн төв: Нийт 28 ажил үйлчилгээ төлөвлөсний 13 нь тусгай ажил үйлчилгээ байна. Төлөвлөсөн ажил үйлчилгээгээ бүрэн хэрэгжүүлсэн.
- Соёлын төв: Нийт 27 ажил үйлчилгээ төлөвлөсний 13 нь тусгай ажил үйлчилгээ байна. Төлөвлөсөн ажил үйлчилгээгээ бүрэн хэрэгжүүлсэн.
- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хувьд үйл ажиллагааны төлөвлөгөөнд 22 ажил тусгагдсанаас 21 нь хэрэгжиж, 1 ажил хэрэгжээгүй.
- Засаг даргын тамгын газрын хувьд үйл ажиллагааны төлөвлөгөөнд 80 ажил үйлчилгээ тусгагджээ. Бүрэн буюу 100 хувийн хэрэгжилттэй 57 ажил үйлчилгээ, 90 хувийн хэрэгжилттэй 19 ажил үйлчилгээ, 70 хувийн хэрэгжилттэй 3 ажил үйлчилгээ, 10 хувийн хэрэгжилттэй 1 ажил үйлчилгээ байна. Нийт ажил үйлчилгээний 95 хувийг 90-100 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

2.4.2. Хөрөнгө санхүүтэй холбоотойгоор хэрэгжээгүй ажил үйлчилгээг эс тооцвол Дарьганга сумын төсөвт байгууллагуудын төлөвлөсөн ажил үйлчилгээ бүрэн хэрэгжсэн байна. Тухайлбал тус сумын Ерөнхий боловсролын сургууль болон Хүүхдийн цэцэрлэг нь үйл ажиллагааны үр дүнгээрээ Сүхбаатар аймгийн хэмжээнд 2016 онд эхний байруудад оржээ.

Дэд зорилт-2. Хууль тогтоомж, эрх зүйн актын биелэлт түүнд тавьж буй дотоод хяналт үр дүнтэй байна уу

3

БҮЛЭГ 3

Төсөв хөрөнгө зарцуулахаар гаргасан сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж бүрэн хэрэгжээгүй бөгөөд архивын баримтын данс бүртгэлийг эс тооцвол дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж байна.

Төсөв хөрөнгө зарцуулахаар гарсан ИТХ-ын тогтоол, засаг даргын захирамж хэрэгжээгүй байна.

3.1.1. Сумын ИТХ-аас 2016 онд 10 тогтоол гарсан. Үүнээс: Сум хөгжүүлэх сантай холбоотой 3 тогтоол гаргаж хяналтын зөвлөлийг шинэчлэн байгуулсан. Дээрх тогтоолын дагуу зээл авсан иргэдтэй уулзалт хийн зээлийг эргэн төлүүлэх талаар хяналтын зөвлөл тодорхой ажил зохион байгуулсан боловч үр дүн хангалтгүй, иргэд зээлээ төлөөгүй байна.

3.1.2. Сумын төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хаваржилтын ажлын талаар авах арга хэмжээ, нийгмийн халамж үйлчилгээ амьжиргааг дэмжих зөвлөлийн тайланг хэлэлцэж цаашид авах арга хэмжээний талаар тогтоол гаргаж бүрэн хэрэгжсэн.

3.1.3. Харин сумын төвийн худалдааны гудамжыг Ц.Дондовдоржийн нэрэмжит болгон нэрлэсүгэй гэсэн 9 тоот тогтоол хэрэгжээгүй, “хаягжуулалтын ажлыг зохион байгуулж зургийг боловсруулж аймгийн, ГХБХБГ-ын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, Геокад ХХК-тай хамтарч ажиллахыг ажлын хэсгийн

бүрэлдэхүүнд үүрэг болгосугай” тогтоол санхүүжилт байхгүйгээс хэрэгжээгүй байна.

3.1.4. Сумын засаг дарга 2016 онд нийт 35 захирамж гаргаж хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар холбогдох албан тушаалтанд үүрэг өгсөн байна. Үүнээс:

- Бог малыг угаалганд хамруулах тухай захирамж хэрэгжээгүй нь малчид малаа дутуу хамруулсан
- Ганга нуурын хамгаалалтад зориулж бэлчээр усжуулалтын тендерт “Ханбулгийн эх” ХХК-ны ирүүлсэн 45000.0 мянган төгрөгийн үнийн санал бүхий төсөл шалгарсан тул уг төслийн гүйцэтгэгчээр томилж ОНХС-аас Ганга нуурын хамгаалалтад зориулж 22500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Тухайн компанийн гаргасан худгыг улсын комисс хүлээн аваагүй бөгөөд 3 ширхэг худаг нь техникийн тодорхойлолтонд заасан шаардлагыг хангаагүй байна.
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж 2016.12.25 ны дотор багтаан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хийж гүйцэтгэхийг Үнэлгээний хорооны дарга Д.Сүхбаатарт үүрэг болгосугай. Уг захирамжаар төсвийн байгууллагад шаардлагатай махны хэрэгцээг хангуулах бэлтгэн нийлүүлэгч сонгон шалгаруулахыг холбогдох албан тушаалтанд үүрэг болгосон боловч ажилчдын нийгмийн асуудлыг шийдэх үүднээс албан хаагчдаас ээлж дараалалтай хэрэгцээний махыг худалдан авдаг болсонтой холбоотойгоор хэрэгжээгүй байна
- Явуулын амбулаторийн үзлэгт зориулж хөрөнгө зарцуулах тухай захирамж санхүүжилт нь шийдэгдээгүй учраас биелээгүй.

Гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлага бүрэн биелэсэн байна.

3.2.1. Акт албан шаардлага зөвлөмжийн биелэлт бүрэн хангагджээ. Харин ОНХСангаас он дамжин хийгдсэн хөрөнгийг данс бүртгэлд аваагүй, сум хөгжүүлэх сангаас авсан зээл хугацаандаа төлөгдөөгүй зөрчил дахин давтагдаж гарсан байна.

Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэжээ.

3.3.1. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын Тамгын газарт 2016 оны байдлаар нийт 15-н өргөдөл гомдол ирсэн байна. Үүнд: Ажилд орохыг хүссэн өргөдөл 2ш, хил хамгаалах тусгай хүчний 1ш, хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 1ш, ЭМТ-ийн удирдлагыг сольж өгөх тухай 2ш, газар чөлөөлж, хохирол барагдуулах тухай 1ш, Үйлчилгээ явуулах боломжтой байраар хангуулах тухай 1ш, газар хүссэн өргөдөл 1ш, хадлангийн газар хүссэн өргөдөл 4ш, “Дарьганга тохижилт үйлчилгээний” нягтлан бодогчтой холбоотой 2ш, нийт 15 өргөдлөөс 14 нь шийдэгдэж, 1 өргөдөл шийдвэрлэгдээгүй байна.

3.3.2. Ажилд орохыг хүссэн өргөдөл: 4-р багийн иргэн Б.Үржинбадам өрх толгойлсон эмэгтэй ажлын байр хүссэн өргөдлийн дагуу ЗДТГ-ын үйлчлэгчээр, Х.Адъяа-БХЭ-ийн ажиллаж байна. Хүүхэд харах үйлчилгээний хүсэлт гаргасан 4-р багийн иргэн Г.Эрдэнэчимэг, Г.Энхтуяа, Г.Цолмон нар үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. ЭМТ-ийн эрхлэгч Д.Нарантуяа өндөр настай аав ээжээ асрах шаардлагатай болсон тул эрхлэгч, эмчийн ажлаасаа чөлөөлөгдөж М.Ганчимэгт шилжүүлэн өгсөн. Б.Чулуунчимэгийн газар хүссэн өргөдөлд гэрчилгээ олгосон. Мөн 2-р багийн малчин М.Дүүрэнбилэг хилийн зурваст нутагладаг тул хил хамгаалах туслах хүчний гишүүнээр орсон. Хадлангийн газар хүссэн иргэд 100-200га газарт өвс хадах зөвшөөрөл олгосон. Мөн "Дарьганга тохижилт ОНӨААТҮГ-ын нябо Б.Оюунтуяагийн өргөдөл шүүхээр эцэслэн шийдэгдсэн байна.

Архивын байнга, түр хадгалах баримтын данс бүртгэлтэй холбоотой алдаа, дутагдлыг эс тооцвол дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж байна.

3.4.1. Засгийн газрын 2011 оны 311 тоот тогтоолын дагуу Сумын ЗДТГ-аас 2014.03.12-ны өдрийн А/35 дугаар захирамжаар дотоод хяналт шалгалт хийх комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилжээ.

3.4.2. Үйлчилгээний газруудад хяналт шалгалт хийх тухай 2016 оны 03-р сарын 24-ний өдрийн А/09 дүгээр захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилон 2 удаа шалгалтыг хийж гарсан зөрчлийг газар дээр нь арилгуулсан байна.

3.4.3. Мөн Засаг даргын 2016 оны 05-р сарын 11 ний өдрийн А/27 дугаар захирамжаар төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилон, удирдамж чиглэлийн дагуу шалгалтыг 8 байгууллагад хийж, дүгнэлт зөвлөмж гарган, тайлан мэдээг холбогдох албан тушаалтанд танилцуулж шийдвэрлүүлсэн байна.

3.4.4. Тус сумын дотоод хяналтын алба төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөг 5 чиглэлээр 8 зорилтын хүрээнд боловсруулан батлуулж дотоод хяналт үр дүнтэй хэрэгжүүлж байгаа боловч өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавиагүй.

3.4.5. Дотоод хяналт шалгалт сумын хэмжээнд хийсэн боловч төсөвт байгууллагуудын архив шаардлага хангахгүй түвшинд байна. Тухайлбал "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт", "Хадгаламжийн нэгжийн бүртгэл"-ийг холбогдох заавар, журмын дагуу хөтлөөгүй байна. Иймд архив, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах талаар аргачилсан зөвлөмж хүргүүлжээ.

ДҮГНЭЛТ

- ❖ Сумын хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажил зохион байгуулж байгаа боловч төсөвт байгууллагуудын архив албан хэрэг хөтлөлтийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.
- ❖ Сумын өмч хамгаалах байнгын зөвлөл нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлууд данс бүртгэлд бүрэн тусгагдсан эсэх талаар тодорхой хяналт тавьж ажиллаагүй байна.
- ❖ Мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан зарим заалтууд хэрэгжээгүй нь төсөвт хөрөнгө дутагдалтай, өөрийн нөөц бололцооноос хэтэрсэн арга хэмжээ төлөвлөсөнтэй холбоотой байна.
- ❖ Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын бүтээгдэхүүний үнэ, татан авахад гарах зардалд харьцуулалт хийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх судалгаа гаргаж, гарсан судалгааг үндэслэн гэрээ байгуулбал зардал хэмнэх боломж байна.

Дарьганга сумын төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад өдөр тутмын үйл ажиллагааны хяналт сайн хэрэгжсэн боловч бодлогын төлөвлөлт, хөрөнгө оруулалтын ажлын бүртгэл, архивын баримтын хөтлөлт, томоохон худалдан авалт зэрэгт зохих түвшний хяналт орхигдсон байна.

ЗӨВЛӨМЖ

1. Сумын үндсэн чиглэл болон холбогдох бусад бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн үе шатанд зохих түвшиний хяналт, шинжилгээг чанаржуулан, сум орон нутгийн төсвийн гүйцэтгэл, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр бодлогын баримт бичгийг боловсруулж байх.
2. Төрийн албан хаагч нарын архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах зорилгоор нэгдсэн сургалт зохион байгуулах, дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулахдаа “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”, “Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт”-ыг шалгуур үзүүлэлт болгон хяналт тавьж, тухай бүр арга зүйн зөвлөгөө өгч хэвших
3. Ажилтан албан хаагч нарын ажлын байрны тодорхойлолтыг Хөдөлмөрийн тухай хуулийн 48.3.2 дахь заалт болон “Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт”-той нийцүүлэх, “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын дагуу үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэж хэвших.

4. Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын бүтээгдэхүүний үнэ, татан авахад гарах зардалд харьцуулалт хийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх судалгаа гаргаж, гарсан судалгааг үндэслэн гэрээ байгуулж зардал хэмнэх боломжийг бүрдүүлэх
5. Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлэгийн ажилтнуудын илүү цагийг Засгийн газрын 1999 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан “Ажлын цагийг нэгтгэн бодох журам”-ын 8⁷, 9⁸-д заасны дагуу нөхөн амруулах зарчмаар зохицуулж, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь /батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;/ заалтыг хэрэгжүүлж ажиллах.

---o0o---

⁷ 8. Тооцоот хугацааны ажлын цагийн фондоос хэтрүүлэн ажилласан цагийг оргил ачааллын бус үед дараахь байдлаар зохицуулна:

а/ ачаалал багатай үед ажлын өдрийн үргэлжлэлийг богиносгох;

б/ долоо хоногийн ажлын өдрийн тоог цөөрүүлэх;

в/ ээлжийн амралт дээр нь нэмэгдэл амралт олгох;

г/ сул зогсолт гарвал өмнөх хугацаанд хэтрүүлэн ажилласан цагт нь тооцож нөхөн амрааж болно.

⁸ 9. Тооцоот хугацааны ажлын цагийн фондоос хэтрүүлэн ажилласан цагаа бүтнээр, эсвэл тодорхой хэсгийг нь биеэр нөхөн амралгүйгээр ажиллах хүсэлтээ албан ёсоор гаргасан ажилтныг ажил олгогч ажиллуулж болно.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН ЗАСАГ ДАРГА


22040 Овоот, Дарьганга сум

2017 - 09 - 25 № 2/109
танай _____ -ны № _____ -Т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж, зөрчил, илэрсэн дутагдлыг цаашид дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллахаа үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА _____ Ц.ГАНХУЯГ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.1-дэх заалтын дагуу Дарьганга сумын Засаг даргад гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүргүүлсэн. Дарьганга сумын Засаг дарга аудитын тайлангийн төсөлтэй танилцаж 2017 оны 09-р сарын 25-ны өдрийн 2/109 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. Ирүүлсэн саналд дараах тайлбар хийлээ. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй ба дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн байна.

Тайлан бичсэн:

Ахлах аудитор *Г.Оюунболд* Г.Оюунболд


Аудитор *О.Барчидгүнсэн* О.Барчидгүнсэн

Аудитор *Э.Алтансүх* Э.Алтансүх

Хянасан:

Тэргүүлэх аудитор *М.Нарантуяа* М.Нарантуяа

Аудитын менежер *Г.Даваа* Г.Даваа





СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/15

Баруун-Урт


Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай


Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 03-р сарын 27-ны өдрийн 121 тоот тушаалаар батлагдсан "Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх"-ийн 5, 11, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 12.40, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төсвийн болон ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Тус аудитаар тогтоосон акт, зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

Гурав. Аудитын тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 22-ны дотор ирүүлэхийг Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг дарга /Ц.Ганхуяг/-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.НАРАНТУЯА



D:/Bichig hereg/2017/tushaal

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын *Э.С. Оныг* сарын *25*-ны өдрийн *А.Н* тоот тушаалын хавсралт

“Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төсвийн болон ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудит

Дугаар	Акт, албан шаардлагын ангилал, код		Алдаа, зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын товч утга	Мөнгөн дүн /сая төгрөг/
1/51	Акт	СБА-2017/04-ГА	Эрүүл мэндийн төвийн үйлчлэгч /асрагч/ нарт 2016 онд 1,002,953 төгрөгийн илүү цагийн хөлс олгоогүй.	Дутуу олгосон илүү цагийн хөлсийг нөхөн олгож, холбогдох шимтгэл, татварыг суутган шилжүүлэх.	1.0
2/52	Акт	СБА-2017/04-ГА	Хүүхдийн цэцэрлэг нь хоолны зардлаас 500000 төгрөгийн бараа материал худалдан авч төсвийг зориулалт бус зарцуулсан.	Зориулалт бус худалдан авсан бараа материалын үнэ 500000 /таван зуун мянган/ төгрөгийг эрхлэгч, нярав нараар төлүүлэх	0.5
1/72	Албан шаардлага	СБА-2017/04-ГА	Өмч хөрөнгийн бүртгэл тайлагналыг нягтлан шалгахад 10000.0 мянган төгрөгийн ногооны талбай, 40618.2 мянган төгрөгийн авто зам, 22500.0 мянган төгрөгийн бэлчээр усжуулах 5 ширхэг худаг, 14500.0 мянган төгрөгийн цэвэр усны шугам нийт 87618.2 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.	Дээрх бус хөрөнгүүдийг холбогдох байгууллагын данс, бүртгэлд тусгаж, биелэлтийг заасан хугацаанд ирүүлэх	87.6
2/73	Албан шаардлага	СБА-2017/04-ГА	Сум хөгжүүлэх сангаас 34 иргэнд 106.8 сая төгрөгийн зээл олгосон боловч зээлийн үндсэн төлөлт, хүүгийн орлогыг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулаагүй.	Дээрх иргэдээр зээлийг төлүүлэх талаар шат дараатай арга хэмжээ авч заасан хугацааны дотор хариу мэдэгдэх	106.8

--- ооо ---